





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



Радио давтамжийн хяналт, хууль бус хэрэглээ

РДЗХГ-ын инженер: Ж.Дөлгөөн

Улаанбаатар хот
2026 он



kHz

MHz

GHz

THz



Хууль эрх зүй

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь Монгол улсын Радио долгионы тухай хуулийн 5.1.2 болон 5.1.4 дэх заалтад заасны дагуу радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан, хараат бус төрийн байгууллага юм.



Тусгай хэрэглээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалтыг тусгай хэрэглээний радио давтамж ашиглах эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах



Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх аргачлалыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих



Монгол улсад бүртгэлтэй радио давтамж, радио давтамжийн зурвасыг Олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх



Хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, тохирлын гэрчилгээ олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих




ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн ХЯНАЛТЫН ТӨВ

Радио давтамжийн хяналтын үйл ажиллагаа Монгол Улсад холбооны салбарын хөгжилтэй зэрэгцэн бий болж, олон арван жилийн турш тасралтгүй хөгжиж ирсэн. 2002 онд Харилцаа холбооны зохицуулах хороо байгуулагдсанаар Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв нь тус хорооны харьяа салбар нэгж болж, радио долгионы ашиглалтын байдлыг суурин болон хөдөлгөөнт хэмжилт, хяналтаар хэрэглэгчид, эрхийн бичиг эзэмшигчид, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн албан хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хэлбэрээр болон хорооны тухайн жилийн бизнес төлөвлөгөөний дагуу радио давтамжийн хэмжилт, хяналтуудыг хийж гүйцэтгэн, холбогдох хууль, журам, стандарт, техникийн нөхцөл, шаардлагын хүрээнд дүгнэлт гарган, холбогдох арга хэмжээг авч, шийдвэрлэн ажиллаж байна. Үүнд:



- Улаанбаатар хотын хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн давтамжийн зурвасын ашиглалтын байдалд хэмжилт хийх, MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох, үр дүнг олон нийтэд мэдээлэх.



- Радио станцуудын зэргэлдээх суваг хоорондын радио давтамжийн нөлөөлөл, зурвасын гаднах цацаргалт, хажуугийн цацаргалт, интермодуляц зэргийг илрүүлэх.



- Монгол улсын зах зээлд нэвтэрсэн болон нийлүүлэгдэх мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжид тохирлын үнэлгээ хийх, шинжээчийн дүгнэлт гаргах.



- Радио давтамжийн хууль бус хэрэглээ, зөвшөөрөлгүй радио станцууд, радио давтамжийн харилцан нөлөөллийг тогтоож, илрүүлэх.



- Радио нэвтрүүлэгч станцын параметруудийг хэмжих, тэдгээрт хяналт тавих.



- Радио станцын радио долгионы хамрах хүрээний тооцоолол хийх, дүгнэлт гаргах.



- Үүрэн холбооны оператор компаниудын 3G, 4G, 5G сүлжээний хамрах хүрээ, ярианы чанар, өгөгдөл дамжуулах хурд зэрэг үзүүлэлтүүдэд хэмжилт хийж, дүгнэлт гаргах.



Радио давтамж гэж юу вэ?

APPLICATIONS OF RADIO FREQUENCY BANDS

ELF (3 Hz – 30 kHz)	LF (30 kHz – 300 kHz)	MF (300 kHz – 3 MHz)	HF (3 MHz – 30 MHz)
Submarine communication Geomagnetic research	Maritime radio Navigation beacons	AM radio Aviation radio	Shortwave broadcast Amateur radio
VHF (30 MHz – 300 MHz)	UHF (300 MHz – 3 GHz)	SHF (3 GHz – 30 GHz)	EHF (30 GHz – 300 GHz)
FM radio, VHF TV Air traffic control	Mobile phones, Wi-Fi Bluetooth, GPS	Satellite communication Radar, 5G	5G mmWave Radio astronomy

Радио давтамж (Radio Frequency) гэдэг нь цахилгаан соронзон долгионы спектрийн радио холбоонд ашиглагддаг хэсгийг хэлнэ. Энэ нь ойролцоогоор 3 кГц-ээс 300 ГГц хүртэлх давтамжийн мужийг хамардаг!

Давтамж гэдэг нь долгион 1 секундэд хэдэн удаа хэлбэлзэж байгааг илэрхийлдэг хэмжигдэхүүн бөгөөд нэгж нь Герц (Hz) юм.



Радио давтамжийг утасгүй холбоо, радио болон телевизийн өргөн нэвтрүүлэг, радарын систем, хиймэл дагуулын холбоо, навигацийн систем зэрэг олон төрлийн хэрэглээнд ашигладаг. Иймээс радио спектр нь хязгаарлагдмал нөөцөд тооцогддог бөгөөд түүний ашиглалтыг Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) болон улс орнуудын үндэсний зохицуулагч байгууллагууд хуваарилан зохицуулдаг.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Олон улсын радио давтамжийн хуваарилалт

Дэлхийн радио давтамжийн хуваарилалт гэдэг нь радио спектрийг (3 кГц–3000 ГГц) олон улсын хэмжээнд зохион байгуулалттайгаар ашиглах зорилгоор үйлчилгээ тус бүрт (өргөн нэвтрүүлэг, хөдөлгөөнт холбоо, хиймэл дагуул, агаарын навигаци гэх мэт) тодорхой зурвасуудыг хуваарилан тогтоосон систем юм.

Энэхүү хуваарилалтыг олон улсын түвшинд Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Радио холбооны сектор (ITU-R) зохицуулдаг. ITU нь дэлхийн улс орнуудын хооронд радио давтамжийн давхцал, хөндлөнгийн нөлөөлөл үүсэхээс сэргийлэх, радио давтамжийн спектрийг үр ашигтай ашиглуулах зорилготой байгууллага.



Радио давтамжийн зурвасуудыг ихэвчлэн дараах үндсэн үйлчилгээний ангиллаар хуваарилдаг. Үүнд: өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ (FM, TV), үүрэн холбоо (2G, 3G, 4G, 5G), суурин болон хөдөлгөөнт хиймэл дагуулын холбоо, радарын систем, агаарын болон далайн навигаци зэрэг орно. Улс бүр энэ олон улсын хуваарилалтын хүрээнд үндэсний зохицуулалтаа хийж, лиценз олголт болон ашиглалтын журмыг тодорхойлдог.



Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв

РДӨНХТ нь Улаанбаатар хотын хэмжээд 20 МГц – 6 ГГц-ийн радио давтамжийн зурвасын ашиглалтын байдалд тогтмол хэмжилт, хяналт хийх зорилгоор доорхи суурин станцуудыг ашиглаж байна.

01

FMS-2014



СХД-ийн 34-р хороо

РДӨНХТ-ийн цамхагт байршил

- FMS-2014 суурин хяналтын систем
- Чиглэл хайгч систем
- 20 МГц – 6 ГГц давтамжийн хүрээ

02

TMDFS



ХУД-ийн 20-р хороо

ТВ-5 телевизийн төв оффисын дээврийн байршил

- TMDFS зөөврийн чиглэл хайгч
- Суурин хяналтын систем
- Телевизийн давтамж хяналт

03

FMS-2020



СБД-ийн 6-р хороо

ХХЗХ-ны төв оффисын дээврийн байршил

- FMS-2020 суурин хяналтын систем
- Чиглэл хайгч систем
- Өргөн зурвасын хяналт



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

MNS ISO/IEC 17020:2013 СТАНДАРТ (ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ)



“Үндэсний итгэмжлэлийн төв”-өөс
“Харилцаа холбооны зохицуулах
хороо”-ны “Радио давтамж, өргөн
нэвтрүүлгийн хяналтын төв”-ийг
“MNS ISO/IEC 17020:2013” тохирлын
үнэлгээ, хяналтын ажил эрхэлдэг
төрөл бүрийн байгууллагын
ажиллагаанд тавих шаардлага”
стандартаар 2025 оны 01-дүгээр
сарын 28-ны өдөр 2 жилийн
хугацаатай техникийн хяналт
гүйцэтгүүлэхээр техник хяналтын
байгууллагаар итгэмжилсэн.



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

MNS ISO/IEC 17020:2013 СТАНДАРТ (ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ)

Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын
2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
А/123 дугаар тушаалын нэгдүгээр хэвсрэлт

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
РАДИО ДАВТАМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХЯНАЛТЫН ГАЗРЫН РАДИО ДАВТАМЖ,
ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВИЙН ИТГЭМЖЛЭЛИЙН ХҮРЭЭНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ**

Хуудас 01/02

Төрөл	Ангилал	Салбар	Цэр хүрээ	Үе шет	Аргачлал
B	Ашиглалтын үеийн хяналт	Радио давтамж Өргөн нэвтрүүлгийн хяналт	Радио өргөн нэвтрүүлэг	Зөөгч давтамж Цахилгаан орны хүчлэг Давтамжийн хазайлт Давтамжийн шилжилт Зурвасын өргөн ЦСО-ны хүчлэгийн зөвшөөрөх хэмжээ	MNS 4909:2000 MNS 5474:2005
			Тоон телевиз	Давтамжийн царраа Орны хүчлэг Зурвасын өргөн Хажуугийн цацаргалт Зурвасын гаднах цацаргалт Гаралтын чадал Дохионы түвшин	MNS 6400:2013 MNS 6401:2013 MNS 6402:2013 MNS 6742:2014
			Үүрэн холбоо	Хажуугийн цацаргалтын түвшин Зурвасын өргөн Давтамжийн спектр маск Чадлын хэмжилт Нэвтрүүлэгчийн чадал Зурвасын өргөн Хамгаалах зурвас Зурвасын гаднах цацаргалт	MNS 6605:2016 MNS 5739:2007 MNS 6611:2016
			Утасгүй өргөн зурвасын үйлчилгээ	Зурвасын өргөн Сувгийн дугаарлалт RSSI Дохио шуугианы харьцаа /SINR/ Хажуугийн цацаргалт	MNS 5741:2007 MNS 6527:2015

Хуудас 02/02

			Зөөгчийн хазайлт EIRP MER	
Газрын станц, төрөл бүрийн нэвтрүүлэгч	Антенны өсгөлт Нэвтрүүлэх талын навчны түвшин Хүлээн авах талын навчны түвшин Зөөгч давтамж Хажуугийн цацаргалтын түвшин EIRP	MNS 5469:2005 MNS 5319: 2003		
Цахилгаан соронзон орон	Цахилгаан орны хүчлэг Чадлын нягт Чадлын нягтын хязгаарын утга	MNS 5594:2020		
Богино зайн радио холбооны тоног төхөөрөмж	Давтамж Давтамжийн царраа Цахилгаан орны хүчлэг Дундаж чадал EIRP	MNS 6545:2015		
Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль болон "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"-д заасан радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хэмжил-хяналтыг гүйцэтгэнэ.				

-----0.0.0-----

“Үндэсний итгэмжлэлийн төв”-ийн даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/10 дугаар тушаалын хэвсрэлтээр “MNS ISO/IEC 17020:2013” стандартаар “Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны “Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв”-ийн итгэмжлэлийн хүрээг тодорхойлж өгсөн.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

MNS ISO/IEC 17020:2013 СТАНДАРТ (ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ)



СКАЙТЕЛ ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Метро бизнес төв, А блок 5 давхар
Д.Сурбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг, УБ-14201-00333
Утас: 30 42 58, Факс: 9716-111 32 77 20
Цахим хуудас: www.crc.gov.mn
Цахим шуудан: info@crc.gov.mn

2026.03.09 № 05/472
танай _____-ны № _____-т

Хэмжилтийн тайлан хүргүүлэх тухай

Танай компаниас 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн 26/1654 тоот албан бичгийн хавсралтад дурдсан байршлууд болох Архангай аймгийн Ихтамир сум, Завхан аймгийн Улиастай, Түдэвтэй, Сонгино сумдын нутаг дэвсгэрт 3G үйлчилгээний радио давтамжийн зурваст үүссэн нөлөөллийг илрүүлэх хэмжилтийг 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Хэмжилтээр Архангай аймгийн Ихтамир сум, Завхан аймгийн Улиастай, Сонгино сумдад танай компанийн ашиглаж байгаа 3G үйлчилгээний радио давтамжийн зурваст радио давтамжийн нөлөөллийн эх үүсвэр илрээгүй болно.

Завхан аймгийн Түдэвтэй суманд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын тоон телевизийн нэвтрүүлэгч станц нь зурвасын гаднах цацаргалт үүсгэж танай компанийн 3G үйлчилгээний радио давтамжийн зурваст нөлөөлөл үзүүлж байгааг хэмжилтээр тогтоосон.

Энэхүү нөлөөлөл үзүүлж байгаа нэвтрүүлэгчийн гаралтад зурвасын шүүр суурилуулж, холбогдох үзлэг, үйлчилгээг хийж зөрчлийг арилгах хугацаатай албан бичгийг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ -т хүргүүлсэн.

Хавсралт: Хэмжилтийн тайлан нийт 17 хуудастай

РАДИО ДАВТАМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  Ц.ЧУЛУУНБАТ



MNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГЧИЙН ХЯНАЛТЫН ТӨВ

РДӨНХТ-ЖУ03-М07



Хэмжилтийн тайлан

Тайлангийн дугаар: 2026/23

Хэвлэсэн огноо: 2026.03.06

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Архангай аймгийн Ихтамир сумын нутаг дэвсгэрт байрлах Скайтел ХХК-ийн бааз станцын 3G сүлжээний радио давтамжид үүссэн харилцан нөлөөллийн шалтгааныг тогтоох, илэрсэн зөрчлийг арилгах.


2. Хэмжилт хийсэн огноо, байршил:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2026 оны 2 дугаар сарын 25-ны өдөр	Архангай аймгийн Ихтамир сумын нутаг дэвсгэр	47°35'45.23"N 101°12'28.04"E



Зураг 1. Архангай аймгийн Ихтамир сумын нутаг дэвсгэрт хэмжилт хийсэн байршил.

7. Хэмжилтийн дүн:



Зураг 3. 810 – 860 МГц-ийн радио давтамжийн зурвасын хэмжилтийн үр дүн.

Маркер	Давтамж	Зурвасын өргөн	Тайлбар
1-2	831 – 841 МГц	10 МГц	Скайтел ХХК (ТЗ-Үүрэн холбоо-24300001)

8. Дүгнэлт:

Хэмжилтээр тус байршилд танай компанид тусгай зөвшөөрлөөр олгогдсон 3G үйлчилгээний радио давтамжийн 831-841 МГц-ийн зурваст радио давтамжийн нөлөөллийн эх үүсвэр хэмжигдээгүй.

Иймд тус бааз станцын тоног төхөөрөмжүүдэд үзлэг, үйлчилгээг хийж, тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа, гэмтэл саатлыг дотооддоо шалгаж, шаардлагатай арга хэмжээг авч, антен хоорондын тусгаарлалтын зайг стандарт хэмжээгээр тооцоолон байршуулсан эсэхэд хяналт тавьж ажиллана уу.

Танилцсан:  Б.Батбаяр /РДӨНХТ-ийн дарга/
Тайлан хянасан:  М.Болдбат /РДӨНХТ-ийн техникийн менежер/
Тайлан боловсруулсан:  М.Дэлгөөн /РДӨНХТ-ийн инженер/





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

РАДИО ДОЛГИОНЫ ХЯНАЛТЫН ЗӨӨВРИЙН ХЭМЖҮҮРИЙН ТӨХӨӨРӨМЖҮҮД



R&S FSH-8
9кГц-8.5ГГц



R&S FSH-20
9кГц-20ГГц



R&S PR200
8кГц-8ГГц



R&S DDF-007
9кГц-7.5ГГц




R&S FPH
5кГц-31ГГц

- Өргөн зурвасын хэмжилт
- Цацаргалтын параметруудийн хэмжилт
- Зурвасын гаднах цацаргалт, Хажуугийн цацаргалт, Гармоник цацаргалт, Интермодуляцын хэмжилт
- Хууль бус радио давтамж болон радио станцын чиглэлийг тодорхойлох хэмжилт
- Спектрийн эзлэмжийн хэмжилт




Суурин станцууд дээр хийгддэг ХЭМЖИЛТҮҮД


Радио давтамжийн өргөн
зурвасын хэмжилт




Хууль бус радио станцын чиглэлийг тодорхойлох
ХЭМЖИЛТ




FM радио станцуудын
нэвтрүүлэгчийн техникийн
нөхцөлд хяналт тавих хэмжилт



Радио давтамж ашиглах ТЗ, ЭБ-ийн
хугацаа дуусгавар болсон радио
давтамжуудыг чөлөөлөх хэмжилт



FM радио станцуудын гармоник
цацаргалтын хэмжилт






ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН РАДИО ДАВТАМЖИЙН ХУВААРИЛАЛТ

ОУЦХБ-ын дээд хэмжээний уулзалт болох Дэлхийн Радио Холбооны Их Хурлаар (ДРХИХ) олон улсын радиогийн дүрэмд өөрчлөлт оруулдаг. Олон улсын радиогийн дүрэмд хийгдсэн өөрчлөлтийг үндэслэж үндэсний радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалтын хүснэгтийг шинэчлэн баталдаг.



2023 онд хуралдсан дэлхийн радио холбооны их хурлын (ДРХИХ-23) шийдвэр, Дэлхийн радио холбооны дүрэм (ITU RR2024)-д оруулсан нэмэлт өөрчлөлтийг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/46 дугаар тушаалаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг шинэчлэн баталсан.



РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАСЫН АНГИЛАЛ

Радио долгионы тухай хуулийн 6-р зүйл. Монгол улсын Радио долгионы хуульд радио давтамжийн зурвасыг ашиглаж буй зориулалтаар нь дараах байдлаар ангилан заасан байдаг.



- **Нийтийн хэрэглээ** (Радио долгионы тухай хуулийн 6-р зүйлийн 6.3 дахь заалт)

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг нийтийн хэрэглээний гэнэ.

- **Тусгай хэрэглээ** (Радио долгионы тухай хуулийн 6-р зүйлийн 6.2 дахь заалт)

Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг тусгай хэрэглээний зурвас гэнэ.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

РАДИО ДАВТАМЖИЙН ХАРИЛЦАН НӨЛӨӨЛӨЛ

Радио давтамжийн харилцан нөлөөлөл гэж тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд хууль бусаар радио давтамж, давтамжийн зурвас ашиглах, болон “Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжид ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нийцээгүй тоног төхөөрөмж ашиглан бусдын радио давтамжийн зурваст нөлөөлөхийг хэлнэ.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Зөвшөөрөлтэй радио давтамжийн зурваст нөлөөлөл үзүүлэх радио холбооны төхөөрөмжүүд

Утасгүй микрофон



Утасгүй микрофонууд түүний хүлээн авагч аудио тоног төхөөрөмжүүд зэрэг нь телевизийн олон суваг дамжуулах радио давтамжийн зурваст нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй байдаг.

RFID АВТОМАТ ХААЛТ



RFID уншигчтай автомашины автомат хаалтууд үүрэн холбооны операторуудад харилцан нөлөөлөл үүсгэнэ.

СҮЛЖЭЭ ӨСГӨГЧ



Баталгаажуулаагүй сүлжээ өсгөгч төхөөрөмж бааз станцын хэвийн ажиллагааг алдагдуулдаг.

DECT УТАСГҮЙ СУУРИН



DECT 6.0 технологийн утасгүй суурин утас нь 2G/4G/3G давтамжид 20-40МГц өргөнтэй сигнал үүсгэнэ.

ХУУЛЬ БУС ХЭРЭГЛЭЭГ ИЛРҮҮЛЭХ ХЭМЖИЛТИЙН ЖИШЭЭНҮҮД



Эрхийн бичгийн зөвшөөрөлгүй ААН

Хэмжилт: Эрхийн бичиг эзэмшигчийн гомдлын дагуу хөдөлгөөнт хэмжилт

Зөвшөөрөлгүй этгээд: Автозамын зураг төслийг гүйцэтгэгч А*** ХХК

Хэмжилтийн үр дүн: Тус хорооноос 16*.225 МГц радио давтамжийг радио давтамж ашиглах эрхийн бичгээр эзэмшигч Нийслэлийн түргэн тусламжийн төвийн авто машинууд. Өөрийн байгууллагын ашиглаж буй радио давтамж дээр шуугиан үүссэн.



Богино зайн радио холбооны төхөөрөмж

Хэмжилт: Эрхийн бичиг эзэмшигчийн гомдлын дагуу хөдөлгөөнт хэмжилт

Нөлөөлөл үзүүлэгч: караоке-н үйлчилгээ эрхлэгч **** ХХК

Хэмжилтийн үр дүн: Тусгай зөвшөөрөлтэй тоон телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллагын 470-694 МГц-ийн радио давтамжийн зурваст утасгүй микрофон нь 684 МГц-ийн радио давтамж дээр нөлөөлөл үзүүлж байсныг зогсоож тус тоон телевизийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зурвасыг гадны хэрэглээнээс чөлөөлсөн.



Машины суурин станц

Хэмжилт: 20МГц-6ГГц-ийн радио давтамжийн зурвасын хэмжилт

Нөлөөлөл үзүүлэгч: Хүнд даацийн тээврийн хэрэгсэл

Хэмжилтийн үр дүн: Хувийн хэрэгцээнд зөвшөөрөлгүй машины суурин станц ашиглаж байсан иргэдийг улсын байцаагчид шилжүүлж, тус байгууллагын радио давтамжийн зурвасыг чөлөөлөв.

ХУУЛЬ БУС ХЭРЭГЛЭЭГ ИЛРҮҮЛЭХ ХЭМЖИЛТИЙН ЖИШЭЭНҮҮД



Сүлжээ өсгөгч төхөөрөмж

Хэмжилт: Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчээс ирсэн гомдлын дагуу

Зөвшөөрөлгүй этгээд: Сүлжээ өсгөгч төхөөрөмж хувь иргэн

Хэмжилтийн үр дүн: Тус хорооноос үүрэн холбооны радио давтамж ашиглах, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч

байгууллагын радио давтамжийн зурваст сүлжээ өсгөгч төхөөрөмж ашиглаж гадны нөлөөлөл үзүүлж байсанг илрүүлж, сүлжээ өсгөгч төхөөрөмжийг унтрааж, үйлчилгээ эрхлэгч байгууллагын хэвийн ажиллагааг хангасан.




Радио өргөн нэвтрүүлгийн хажуугийн цацаргалт

Хэмжилт: 20МГц-6ГГц-ийн радио давтамжийн зурвасын хэмжилт

Нөлөөлөл үзүүлэгч: РӨН-ийн үйлчилгээ эрхлэгч

Хэмжилтийн үр дүн: РӨН-ийн үйлчилгээ эрхлэгч байгууллагын FM радио станцын нэвтрүүлэгч станц нь ИНҮТ-ийн эрхийн бичгийн зөвшөөрлөөр олгосон радио давтамжийн зурваст нөлөөлөл орж байсныг илрүүлсэн хууль бус хэрэглээг зогсоосон.



Хүнд даацын машины суурин станц

Хэмжилт: 20МГц-6ГГц-ийн радио давтамжийн зурвасын хэмжилт

Нөлөөлөл үзүүлэгч: Хүнд даацын тээврийн хэрэгсэл

Хэмжилтийн үр дүн: Хувийн хэрэгцээнд зөвшөөрөлгүй машины суурин станц ашиглаж байсан иргэдийг улсын байцаагчид шилжүүлж, тус байгууллагын радио давтамжийн зурвасыг чөлөөлөв.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА!

Thank you for your attention

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо – Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв

📍 Метро бизнес төв А-блок 5 давхар, Д.Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг, УБ 14201-0033
☎ +976-11-304258 | 🌐 www.crc.gov.mn | ✉ info@crc.gov.mn